

Аудитын ерөнхий дүгнэлт: **Аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогын төлөвлөгөөг 112.9 хувиар буюу 1650.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.**

Аудитын нэр:

ТӨВ АЙМГИЙН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**Зуунмод
2017 он**

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар.....3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....4
Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал	Аудитын дүн.....
Аудитын менежер О.Амаржаргал	БҮЛЭГ -1 2016 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийг баримталж ажилласан байна..... 5-8
Аудитор Ц.Саранчимэг Ц.Базарсад А.Батлхагва	БҮЛЭГ- 2 Аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогын төлөвлөгөө 112.9 хувиар буюу 1650.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. 9-11
	БҮЛЭГ- 3 Нэгдсэн төсвийн урсгал зардал 4526.9 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсан байна 12-17
2017 оны 04 дугаар сарын 28	Дүгнэлт.....18
	Зөвлөмж.....19
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал20
http://audit.mn/	Хавсралт №1.....21
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 22582 дугаарын факсаар харилцана уу.	
ХАЯГ:	
Төв аймгийн Төрийн байгууллагын 2-р ордон	

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний Аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
НХХС	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААН	Аж ахуйн нэгж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
ХК	Хувьцаат компани
ҮХААЯ	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам
АТБӨЯХ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төв аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт: Төв аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

- 1.Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- 2.Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- 3.Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Аудитын хамрах хүрээ: Аудитаар орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, ТЕЗ болон орон нутгийн ТЕЗ-чид, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн хууль
- Хүнийн хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Хүний хөгжил сангийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Төв аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Ц.Саранчимэг, Ц.Базарсад, шинжээч А.Батлхагва нар 2017 оны 04-р сарын 20-ноос 04-р сарын 28-нийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Бүлэг 1

2016 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийг баримталж ажилласан байна.

1.1 2016 оны нэгдсэн төсөв, Төсвийн тусгай шаардлагуудыг хангаж зорилтот түвшинд хүрч чадсан уу?

2016 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийг баримталж ажилласан байна.

Сангийн яамнаас 2016 оны орон нутгийн төсвийг боловсруулах, батлуулахдаа дараах зарчмыг баримтлах чиглэлийг ирүүлсэн байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсөвт хэмнэлтийн горимыг мөрдөж, тэвчиж болох урсгал зардлыг бууруулах, нийт зардлын өсөлтийг хязгаарлах
- ✓ Орон нутгийн төсөвт байгууллагуудын бүтцийг цомхон, чиг үүргийн давхардалгүй зохион байгуулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, урсгал зардлыг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх
- ✓ Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх
- ✓ Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг тэргүүлэх чиглэл, хүрэх үр дүн, ач холбогдлоор нь эрэмбэлэх замаар төсвийн хөрөнгийг оновчтой хуваарилж, төсвийн боломжит нөөцөд багтаан хэрэгжүүлэх
- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ашиглалттай холбоотой урсгал зардлыг орон нутаг бие даан санхүүжүүлэх

Орон нутгийн түвшинд эдгээр чиглэлийг хэрхэн хангаж ажилласан талаар шалгуур болгож авч үзлээ.

2016 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулах, төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийг баримталж ажилласан байна.

1.2. 2016 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг тайлант хугацаанд 2 удаа тодотгон баталсан байна.

Төв аймгийн ИТХ-ын 2015.12.04-ний өдрийн 11-р хуралдааны 09 тоот тогтоолоор 2016 оны төсвийн орлогын нийт төлөвлөгөөг 66116.8 сая төгрөгөөр, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг 59.4 сая төгрөгөөр баталсан.

2016 оны төсвийн орлого, эх үүсвэрийн төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Орлого, тусламжийн төрөл	Аймгийн ИТХурлын хуралдааны			Сумдын ИТХ-ын тогтоол	Нийт орлого, эх үүсвэр
	2015.12.04-ны 09 тоот тогтоол	2016.03.23-ны 05 тоот тогтоол	2016.10.14-ны 02 тоот тогтоол		
татварын орлого	10,059.30	10,059.30	10,105.10	2,120.20	12,225.30
татварын бус орлого	221.6	221.6	221.6	314.7	536.3
УТ-ийн санхүүгийн дэмжлэг	8,913.30	8,913.30	8,841.00		8,841.00
ОНХС-ийн шилжүүлэг	6,679.80	6,679.80	6,300.90		6,300.90
ТЗШ	40,242.80	40,242.80	40,606.10		40,606.10
Төсвийн шилжих үлдэгдэл		3,346.40	3346.4	649.3	3995.7
ОНХС-ийн шилжих үлдэгдэл		93.6	93.6	355.9	449.5
ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	59.4	59.4	69.4		97.8
Тогтоолоор баталсан орлогын дүн	66,176.20	69,616.20	69,584.10	3,440.10	73,052.60
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх			182.8	1,472.00	1,654.80
Нийт орлогын дүн	66,176.20	69,616.20	69,766.90	4,912.10	74,707.40

2016 онд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас анхны баталсан төсвийн орлого, эх үүсвэрийн төлөвлөгөөг 2 удаа өөрчлөн тодотгосон байна. Үүнд:

- ✚ Төв аймгийн ИТХ-ын 2016.03.23-ний өдрийн 12-р хуралдааны 05 тоот тогтоолоор төсвийн нийт орлогыг 69556.8 сая төгрөг, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг 59.4 сая төгрөг буюу нийт орлого 69616.2 сая төгрөгөөр баталж анхны төлөвлөгөөнөөс 3440.0 сая төгрөгөөр нэмж тодотгосон. Үүнд:
 - ✓ Тодотголоор төсвийн шилжих үлдэгдэл 3346.4 сая төгрөг, аймаг ОНХС-ийн шилжих үлдэгдэл 93.6 сая төгрөгөөр буюу нийт 3440.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- ✚ Төв аймгийн ИТХ-ын 2016.10.14-ний өдрийн 2-р хуралдааны 02 тоот тогтоолоор, ИТХ-ын 12-р хуралдаанаас баталсан төсвийн нийт орлого, эх үүсвэрийн төлөвлөгөөг 69584.1 сая төгрөг болгон, 32.1 сая төгрөгөөр өмнөх тодотгосон төлөвлөгөөг бууруулан тодотгосон. Үүнд:
 - ✓ Татварын болон татварын бус орлого 11.3 сая төгрөг, ТЗШ-ийн байгууллагуудын шилжүүлэг 363.3 сая төгрөг, ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого 10.0 сая төгрөгөөр нэмэгдэж, УТ-ийн санхүүгийн дэмжлэг 72.3 сая төгрөг, ОНХС-агийн орлогын шилжүүлэг 378.9 сая төгрөгөөр буурсан байна.

Төв аймгийн 27 сумын ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн төсвийн татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг 2434.9 сая төгрөгөөр баталсан.

Сумдын ИТХ-ын хуралдаанаас Төсвийн шилжих үлдэгдэл 649.3 сая төгрөг, ОНХС-агийн шилжих үлдэгдэл 355.9 сая төгрөг, 3440.1 сая төгрөгийг зарцуулахаар тодотгосон.

2016 оны сумдын орлого, эх үүсвэрийн төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:
/сая төгрөг/

Сумдын нэр	Сумдын								
	Орон нутгийн орлого			ОНО-ын шилжих үлдэгдэл			ОНХС-агийн шилжих үлдэгдэл		
Алтанбулаг	2015.12.18	3	153.7	2016.05.05	4	23.9			
Аргалант	2015.12.16	7	35.3	2016.02.25	7	0.3			
Архуст	2015.12.16	1	24.0	2016.03.29	1	3.6	2016.03.29	1	2.8
Батсүмбэр	2015.12.21	3	157.9	2016.12.19	3	54.1			
Баян	2015.12.22	1	51.6	2016.11.23	2	4.8	2016.11.23	2	74.5
Баяндэлгэр	2015.12.21	4	43.3	2016.04.19	1	55.2	2016.04.19	1	17.1
Баянжаргалан	2015.12.18	1	18.9			0.0	2015.12.18	7	79.8
Баян-өнжүүл	2015.12.20	3	87.3	2016.07.20	1	47.3	2016.12.15	3	16.3
Баянхангай	2015.12.17	2	36.7	2016.02.18	1	2.1	2016.02.18	1	37.9
Баянцагаан	2016.11.30	3	42.1	2016.07.06	1	63.8			
Баянцогт	2015.12.18	3	25.1	2016.07.07	3	5.2	2016.07.07	3	9.6
Баянчандмань	2016.10.26	62	107.1	2016.02.15	5	14.6			
Борнуур	2015.12.18	10	73.9	2016.04.07	3	17.2			

Бүрэн	2015.12.17	5	52.4	2016.07.27	4	0.9			
Дэлгэрхаан	2015.12.21	5	16.6	2016.02.02	2	5.5			
Жаргалант	2016.11.23	1	264.9	2016.04.12	2	21.9	2016.04.12	2	22.8
Заамар	2015.12.17	6	100.3			0.0	2015.12.17	6	44.1
Лүн	2015.12.16	1	132.1	2016.05.04	1	49.9			
Мөнгөнморьт	2016.11.22	1	231.1	2016.02.18	1	103.0			
Өндөрширээт	2016.07.04	11	80.6			0.0			
Сэргэлэн	2015.12.18	24	97.2	2015.12.18	1	44.3	2015.12.18	1	38.8
Сүмбэр	2015.12.19	6	36.5	2016.02.15	6	7.4			
Угтаал	2015.12.21	3	43.2	2016.02.01	9	14.0			
Эрдэнэ	2015.12.14	5	151.4	2016.02.26	1	16.1			
Цээл	2016.11.30	6	45.7	2016.11.30	6	7.9			
Эрдэнэсант	2015.12.17	6	60.9	2016.04.07	1	41.3	2016.04.07	1	12.3
Зуунмод	2015.12.18	4	265.5			45.0			
			2434.9			649.3			355.9

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн 11-р хуралдааны 09 тоот тогтоолоор Төв аймгийн 2016 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын нийт хэмжээг 66176.2 сая төгрөгөөр баталсан.

Төв аймгийн 2016 оны төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөөг 2 удаа тодотгон баталсан байна. Үүнд:

- ✚ Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 03-р сарын 23-ний 05 тоот тогтоолоор 69616.2 сая төгрөгөөр буюу анхны батлагдсан төлөвлөгөөг 3440.0 сая төгрөгөөр нэмж тодотгосон. Нэмж тодотгосон зардлыг ангилвал төсвийн хэмнэлт урамшуулалын зардал 777.5 сая төгрөг, хөрөнгийн зардал 2568.9 сая төгрөгөөр тодотгосон байна.
- ✚ Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10-р сарын 14-ний 02 тоот тогтоолоор 69584.1 сая төгрөг болгон өмнөх тодотгосон төлөвлөгөөнөөс 32.1 сая төгрөгөөр бууруулан тодотгосон.

Төв аймгийн 2016 оны төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулан хүснэгтээр харуулбал /сая төгрөг/

Сайдын багцаар	2015 он	2016 он		өсөлт бууралт	
	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Аймгийн Засаг дарга	31608.4	34,010.90	30,921.00	-2,402.50	-2,264.10
БСУШУСайд	29578.9	33,113.30	31,810.10	-3,534.40	-3,169.20
БХБСайд	244.4	230.5	230.4	13.9	9.8
ХНХСайд	288.2	277.6	269.1	10.6	9.8
ЭМСайд	7598	7,075.10	6,957.50	522.9	374
ДҮН	69317.9	74,707.40	70,188.10	-5,389.50	-5,039.70

Дээрх хүснэгтээс үзвэл 2016 оны төсвийн жилд зарцуулах зарлагын батлагдсан төлөвлөгөө нь өмнөх оны батлагдсан төлөвлөгөөнөөс нийт дүнгээр 5389.5 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлээс 5039.7 сая төгрөгөөр өссөн байна.

2016 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг өмнөх оны зарлагын гүйцэтгэлтэй харьцуулахад аймгийн Засаг даргын төсөв 2402.5 сая төгрөгөөр, БСУШУС-ын харьяа байгууллагууд 3534.4 сая төгрөгөөр өссөн, Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллагууд 522.9 сая төгрөгөөр, БХБС-ын харьяа байгууллага 13.9 сая төгрөгөөр, ХНХС-ын харьяа байгууллага 10.6 сая төгрөгөөр тус тус буурсан дүнтэй байна.

Өссөн шалтгааныг дурьдвал:

- ✚ Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагын хүрээнд
 - ✓ Сумдад ЗГ-ын 326-р тогтоолын дагуу санхүүгийн алба байгуулагдсантай холбоотойгоор цалин, НДШимтгэл нэмэгдсэн

- ✓ Төвлөрсөн халаалтын системд холбогдсонтой холбоотойгоор Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор Баянхангай, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Борнуур, Бүрэн сумдын халаалтын 1м³-ийн үнийг шинэчлэн батлагдсан.
- ✓ Цахилгааны 1 квт-ийн үнийн өөрчлөлттэй холбоотойгоор үнэ өссөн.
- ✓ Төрийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн зардал нэмэгдсэн.

БСШУС-ын багцын төсвийн хүрээнд

- ✓ Зуунмод сумын Дэгдээхий цогцолбор, Алтанбулаг, Архуст, Баянцогт, Сүмбэр, Угтаал, Цээл сумдын цэцэрлэгүүдэд нийт 9 бүлэг нэмэгдсэн, мөн Зуунмод сумын “Адтай жаалууд”, “Мандахнаран”, Батсүмбэр сумын “Эрхэм жаалууд” хувийн цэцэрлэгүүдийн хувьсах зардал, багш, туслах багшийн орон тоо, цалин, хоол, бусад зардлууд нэмэгдсэн.
- ✓ Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2013 оны 05 сарын 08-ны өдрийн 02 тоот тогтоолоор дулааны өртгийг Зуунмод суманд 1м³ НӨАТ-гүй 1900 төгрөг, мөн 2014 оны 07 сарын 17 -ны өдрийн 05 тоот тогтоолоор дулааны өртгийг 1м³ НӨАТ-гүй Заамар суманд 1050 төгрөг, Угтаалцайдам суманд 1260 төгрөг, Дэлгэрхаан суманд 1450 төгрөг, Жаргалант суманд 1150 төгрөг, Цээл суманд 1200 төгрөг, Лүн суманд 1250 төгрөг, Заамар сумын Хайлааст багт 1300 төгрөг, Батсүмбэр суманд 900 төгрөг, тус зөвлөлийн 2015 оны 07 сарын 20 -ны өдрийн 08, 09, 10, 11 тоот тогтоолуудаар дулааны өртгийг 1м³ НӨАТ-гүй Баянчандмань суманд 1050 төгрөг, Борнуур, Баянхангай суманд 1200 төгрөг, Баян-Өнжүүл, Өндөрширээт суманд 1350 төгрөг, Бүрэн суманд 1000 төгрөгөөр тус тус халаалтын зардлууд нэмэгдсэн.
- ✓ Хот суурингийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны 06 сарын 15-ны өдрийн 23 тоот тогтоолоор Зуунмод сумын цэвэр усны тариф 1м³ НӨАТ-гүй 2000 төгрөг, бохир усны тариф 1м³ НӨАТ-гүй 1650 төгрөг болсноор ЕБС-иудын цэвэр бохир усны зардал, цэцэрлэгүүдийн цэвэр бохир усны зардал нэмэгдсэн.

1.3 Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг зөв бодитой тооцсон уу?

2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 2016 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар бүлэгийн орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 8913.3 төгрөгөөр батлагдсан. Аймгийн ИТХурлын 2 дугаар хуралдааны 2016 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн № 02 тоот “Аймгийн 2016 оны төсвийн тодотгол батлах” тухай тогтолын 9.2-т аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 8841.0 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төв аймаг нь 2016 онд төсвийн суурь орлого, суурь зарлагын зөрүүгээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 8841.0 сая төгрөг авахаар батлагдснаас гүйцэтгэлээр 8841.0 сая төгрөгийн санхүүжилтыг бүрэн авсан байна.

Бүлэг 2

Аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогын төлөвлөгөө 112.9 хувиар буюу 1650.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.1 Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээг бүрэн авч чадсан уу?

Төв аймгийн 2016 оны төсвийн эх үүсвэр бүрэн санхүүжигдэж, татварын орлого давж биелэснээс 822.9 сая төгрөгөөр эх үүсвэр нэмэгдсэн байна.

Төв аймгийн 2016 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас 74707.4 сая төгрөгөөр баталсан. 2016 оны төсвийн нийт орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 9925.7 сая төгрөгөөр өссөн ба тайлант оны батлагдсан төлөвлөгөөнөөс 822.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- ✚ Өмнөх оноос гүйцэтгэл өссөн нь татварын орлого 1809.8 сая төгрөг, ОНХСангийн шилжүүлэг 2483.9 сая төгрөг, ТЗ-ийн шилжүүлэг 3703.4 сая төгрөг нэмэгдсэнтэй холбоотой байна.
- ✚ Тайлант онд татварын болон татварын бус орлого 1650.1 сая төгрөгөөр давж биелэсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлого эх үүсвэр /сая төгрөг/

орлого, тусламжийн төрөл	өмнөх оны гүйцэтгэл	2016 оны		өмнөх оноос өссөн, буурсан	төлөвлөгөө-ний биелэлт
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
Татварын орлого	11187.9	12225.3	12997.7	1809.8	772.4
Татварын бус орлого	1801.8	471.9	1390.7	-411.1	918.8
Хөрөнгийн орлого	52.7	64.4	22.8	-29.9	-41.6
УТ-ийн санхүүгийн дэмжлэг	9358.8	8841.0	8841.0	-517.8	0
ОНХС-ийн шилжүүлэг	3817	6300.9	6300.9	2483.9	0
ТЗ-ийн шилжүүлэг	36905.4	40606.1	40608.8	3703.4	2.7
Төсвийн шилжих үлдэгдэл	2397.4	4445.2	3716.4	1319	-728.8
ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	83.6	97.8	52.1	-31.5	-45.7
Дүн	65604.6	73052.6	73930.4	8325.8	877.8
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		1654.8	1599.9	1599.9	-54.9
Нийт орлогын дүн	65604.6	74707.4	75530.3	9925.7	822.9

Төв аймгийн төсөвт төвлөрөх 2016 оны татварын буюу урсгал орлогыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 04 ний өдрийн 11-р хуралдааны 09 тоот тогтоолоор татварын буцаан олголтыг хассанаар 10280.9 сая төгрөгөөр баталсан.

Татварын орлогын 2016 оны төлөвлөгөөнд аймгийн ИТХ-ын хуралдаанаар 1 удаа тодотгол хийгдсэн байна. Үүнд:

- Төв аймгийн ИТХурлын 2016 оны 10-р сарын 04-ны өдрийн 2-р хуралдааны 02 тоот тогтоолоор хувь хүний орлогын албан татварын буцаалтыг 45.7 сая төгрөгөөр

бууруулж, 2016 оны батлагдсан татварын буцаан олголтыг хассанаар татварын урсгал орлогыг 10326.6 сая төгрөгөөр тодотгон баталсан.

Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 2434.9 сая төгрөгөөр баталсан. 2016 оны аймгийн урсгал төсвийн орлого нийт 12761.6 сая төгрөгөөр батлагдсан байна.

2016 оны аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 15115.4 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 704.2 сая төгрөгийг хасч тооцоход 14411.2 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 112.9 хувиар буюу 1650.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.2 Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн хүчин зүйлс бодитой байна уу?

Аймаг сумын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын болон татварын бус орлого 7 нэр төрлийн татвар 8.8-39.0 хувиар тасарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 16 нэр төрлийн орлогын төлөвлөгөө биелэж, үйл ажиллагааны орлогын татвар, бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, ТТАМАТөлбөр, үндсэн хөрөнгө борлуулсны орлого, ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр, өмч хувьчлалын орлого зэрэг нь 8.8-39.0 хувиар тасарсан байна. Үүнд:

- ✓ Үйл ажиллагааны татвар дийлэнх сумдад хувь хүн бизнес эрхлэгчдээс авах татварыг оны эхэнд Сангийн яамнаас төлөвлөсний дагуу өндөр тогтоосон нь зарим сумдад энэхүү хууль нь хэрэгжихэд бэрхшээлтэй е баримт хэвлэгдэн гарах машин байрлуулах нөхцөлийг бүрдүүлээгүй, орлогыг тодорхойлох боломжгүйгээс орлого буурсан.
- ✓ Бууны татвар татварын улсын байцаагчдын үйл ажиллагаанаас шалтгаалсан.
- ✓ Ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр Батсүмбэр суманд ихэнх ойн төлбөрийн орлого төвлөрдөг бөгөөд 2016 оны хувьд цас их унаснаас аж ахуй нэгж, нөхөрлөлүүд гоожингийн зөвшөөрөл бага авсан мөн хэрэглээний мод бэлтгэх нь ч бага байсан.
- ✓ Улсын тэмдэгтийн хураамж Баян, Баянхангай, Угтаал, Сүмбэр, Эрдэнэсант сумдууд 40-60 хувийн биелэлттэй байгаа нь бусад сумдтай харьцуулахад нотариатын орлого төлөвлөсөн хэмжээнд ороогүйтэй холбоотой.

2016 оны татварын ба татварын бус орлогын бүтэц /сая.төгрөг/

орлогын нэр төрөл	Аудитлагдсан дүн		Биелэлт өссөн+ буурсан-	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
Хувь хууний албан татвар	6,724.3	6,769.5	45.2	100.7
Мал бүхий иргэний орлогын албан татвар	-	0.9		
Үйл ажиллагааны орлогын албан татвар	587.8	358.7	-229.1	61.0
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар	184.9	363.5	178.6	196.6
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	281.9	445.6	163.7	158.1
АТБӨЯХэрэгслийн татвар	270	336	66.0	124.4
Бууны албан татвар	30.8	28.1	-2.7	91.2
Улсын тэмдэгтийн хураамж	292.1	276	-16.1	94.5
Газрын төлбөр	1,482.4	1,661.0	178.6	112.0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	13.4	39.3	25.9	293.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	193	184.7	-8.3	95.7
Ус ашигласны төлбөр	1,414.7	1,841.5	426.8	130.2
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	185.1	331	145.9	178.8
Ойн төлбөр	215.2	151.9	-63.3	70.6
Байгалийн ургамал ашигласны төлбөр	127	455.6	328.6	358.7

Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	147.2	114.8	-32.4	78.0
Түрээсийн төлбөр	23.2	37.5	14.3	161.6
Хүү торгууль	690.2	823.2	133.0	119.3
Нэр зааж ангилагдаагүй орлого	275.6	583.6	308.0	211.8
нохойны татвар	1	1.5	0.5	150.0
хог хаягдал	168.3	181.9	13.6	108.1
Өмч хувьчлалын орлого	64.4	22.7	-41.7	35.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого	92.8	106.9	14.1	115.2
Дүн	13,465.3	15,115.4	1,650.1	112.3
Буцаан олголт	704.2	704.2	0.00	100.0
Татварын буцаан олголт хассан дүн	12,761.1	14,411.2	1,650.1	112.9

Төв аймгийн Татварын хэлтсийн 2016 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээгээр аймгийн төсөвт төвлөрсөн орлогын мэдээ нь төрийн сангийн харилцах дансны хуулгын дүнгээс зөрүүтэй мэдээлэгдсэн байна. Үүнд:

- ✓ Аймгийн төсөвт төвлөрөх нэр зааж ангилагдаагүй орлого дансанд 159.1 сая төгрөг орсон байхад 126.8 сая төгрөгөөр мэдээг гаргаж, 32.3 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн.
- ✓ Цэргийн дүйцүүлэх албаны дансанд орсон 47.7 сая төгрөгийг орлогоор огт мэдээлээгүй.
- ✓ АТБӨЯХТатварын орлого 336.0 сая төгрөг орлогын дансанд орсон байхад 19.5 сая төгрөгөөр дутуу буюу 316.5 сая төгрөгөөр мэдээлсэн байна. Энэ нь гадны дугаар бүхий авто машины тээврийн хэрэгсэлийн татварыг хасч тооцсонтой холбоотой байна.

орлогын нэр төрөл	Аудитлагдсан дүн		татварын хэлтсийн мэдээгээр		аудитлагдсан тайлан, татварын мэдээний зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	6,724.3	6,769.5	6,724.3	6,768.3	1.2
АТБӨЯХэрэгслийн татвар	270	336	270	316.5	19.5
Газрын төлбөр	1,482.4	1,661.0	1,482.4	1,659.0	2
Ус ашигласны төлбөр	1,414.7	1,841.5	1,414.7	1,838.5	3
Агнуурын нөөц ашигласны	185.1	331	185.1	299	32
Ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр	215.2	151.9	215.2	152.1	-0.2
Хүү торгууль	690.2	823.2	690.2	820.1	3.1
Нэр зааж ангилагдаагүй орлого	275.6	583.6	275.6	586.8	-3.2
ТБӨОрлого	92.8	106.9	92.8	105	1.9

2.3 Орлогын бүх гүйлгээ тухайн төсөв захирагчийн төрийн сангаар дамжин хийгдэж чадаж байна уу?

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд төрийн сангийн чиг үүргийг төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих, төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх, төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх, төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох, төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих, төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх, төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах, төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох талаар хуульчилан заасан байна.

Аймаг, сумдын Төрийн сан нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу төсвийн байгууллагын бүртгэлийн дансыг батлагдсан төсвийн хуваарийн дагуу орлого, зарлагын гүйлгээг хянаж, төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон сумдын эргэлтийн эмийн сангуудын орлого арилжааны банкаар хийгдэж бусад бүх орлогын гүйлгээ төсөв захирагчийн төрийн сангаар дамжин хийгдэж байна.

Бүлэг 3

Төв аймгийн 2016 оны төсвийн урсгал зардал 4526.9 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсан байна

3.1 Төсвийн зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв байна уу?

Төв аймгийн 2016 оны төсвийн урсгал зардал 4526.9 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсан байна

Төв аймгийн ТЭЗ-ийн 2016 оны жилийн эцсийн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 74707.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 70180.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 4529.9 сая төгрөг дутуу зарцуулсан буюу биелэлт 93.94 хувь байна. Төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 5032.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

2016 оны төсвийн урсгал зардал гүйцэтгэлээр 4526.9 сая төгрөг хэмнэгдсэн шалтгаан нь санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд дараах мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үүнд :

- ✚ 2016 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 96.6 хувь буюу 7402.6 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.
- ✚ Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал ОНӨО данс 4006.8 сая төгрөг, төсөвт байгууллагуудын үлдэгдэл 0.8 сая төгрөг, ОНӨҮГазруудын үлдэгдэл 93.2 сая төгрөг, тусгай сангуудын үлдэгдэл 3550.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн үлдэгдэл 8.6 сая төгрөгийг тус тус эзэлж байна.
- ✚ ТЭЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7659.4 сая төгрөг буюу өмнөх оноос 1833.1 сая төгрөгөөр өссөн нь тусгай сангуудын үлдэгдэл өмнөх оноос 2081.9 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байгууллагын төрлөөр

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
ОН-ийн ерөнхий орлого	4157.6	4006.8			4006.8
Сумын орлогын үлдэгдэл	810.4	1156.3			1156.3
Аймгийн ерөнхий орлого	3347.2	2850.5			2850.5
Төсөвт байгууллага	0.9	0.8		0.8	
ОНӨҮГ	122	93.2	4.1	89.1	
Сангууд	1468.3	3550	0.7	162.1	3387.2
Нэмэлт санхүүжилтийн	77.5	8.6			8.6
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	5,826.3	7659.4	4.8	252	7402.6

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 74707.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 70180.5 сая төгрөгийг зарцуулсныг эдийн засгийн ангилаар хүснэгтээр харуулав.

Нийт зардлын бүтцийг эдийн засгийн ангилалаар харуулбал / сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	өмнөх үеэс өсөлт /+/, бууралт /-/	гүйцэтгэлд эзлэх хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65148.4	74707.4	70180.5	5032.1	100.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	30884.5	30879.0	30659.1	-225.4	43.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3380	3405.9	3347.7	-32.3	4.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6688.7	9090.6	8923.3	2234.6	12.7
Хангамж, бараа материалын зардал	853.9	1037.1	1021.3	167.4	1.5
Нормативт зардал	2768	3101.4	3035.2	267.2	4.3
Эд хогшил, урсгал засварын зардал	208.4	218.0	219.6	11.2	0.3
Томилолт, зочны зардал	199.4	142.7	132.3	-67.1	0.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	352.4	887.5	824.3	471.9	1.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2774.8	6843.9	6598.4	3823.6	9.4
Хүү	44	0.0	0.0	-44.0	0.0
ТАТААС	123.1	377.9	377.9	254.8	0.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7656	9810.5	8633.6	977.6	12.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9215.3	7233.2	5139.1	-4076.2	7.3
Эргэж төлөгдөх зээл		1679.7	1268.9	1268.9	1.8

Дээрх хүснэгтээр харахад нийт зарлагын 90.3 хувийг дараах 5 зардал эзэлж байна. Үүнд:

- Цалин хөлс, ажил олгогчоос олгох зардал нийт зарлагын 48.5 хувь буюу 34006.8 сая төгрөгийг,
- Хөрөнгийн зардал нийт зарлагын 7.3 хувь буюу 5139.1 сая төгрөгийг,
- Бараа үйлчилгээний бусад зардал нийт зардлын 9.4 хувь буюу 6598.4 сая төгрөгийг,
- Урсгал шилжүүлэг буюу нийгэм халамжийн зардал нийт зардлын 12.3 хувь буюу 8633.6 сая төгрөгийг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал нийт зардлын 12.7 хувь буюу 8923.3 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2234.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3536.5 сая төгрөг, урсгал шилжүүлэг 1010.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Өссөн шалтгааныг тодруулахад:

- ✓ Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор дулааны өртгийг нэмсэнтэй холбогдуулан ЕБС-иудын халаалтын зардалд 608.5 сая төгрөг, цэцэрлэгүүдийн халаалтын зардалд 95.5 сая төгрөг, соёлын төвүүдийн халаалтын зардалд 459.8 сая төгрөг, нам даралтын уурын зуухтай бусад сумдын сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдийн халаалтын зардалд нэг тн нүүрсний үнэ, тээврийн зардлын үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 416.8 сая төгрөг, нийт 1580.6 сая төгрөгөөр өмнөх оны халаалтын зардлаас өссөн байна. Мөн Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоолоор ЕБС-иудын цэвэр бохир усны зардалд 35.7 сая төгрөг, цэцэрлэгүүдийн цэвэр бохир усны зардалд 18.7 сая төгрөг, нийт 54.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- ✓ Орон нутгийн төсөвт бараа үйлчилгээний зардалд орон нутгийн шилжих үлдэгдлээр санхүүжигдэх зардлуудыг төлөвлөсөн ба 2015 оны гүйцэтгэлээс нэмэгдсэн. 2016 оны шилжих үлдэгдэл аймагт 3364.4 сая төгрөг, суманд 649.3 сая төгрөгөөр тус тус төсөвт тусгагдан зарцуулагдсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн захирагчаар авч үзэхэд нийт зарцуулалтын 44.1 хувийг буюу 30921.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын багц, 45.3 хувийг буюу 31810.1 сая төгрөгийг БСШУЯамны багц, 9.9 хувийг буюу 6957.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн багц эзэлж байна. Өмнөх оноос Аймгийн засаг дарга 2264.1 сая төгрөгөөр,

БСУШУС 3169.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, БХБС-ийн багц 9.8 сая төгрөгөөр, ХНХСайдын багц 9.8 сая төгрөгөөр, ЭМС-ын багц 374.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг салбараар харуулбал /сая төгрөгөөр/

Сайдын багцаар	2015 он		2016 он			өсөлт бууралт	
	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Эзлэх хувь	хэмнэлт/+/ хэтрэлт /-/	төлөвлөгөө	гүйцэтгэл
Аймгийн Засаг дарга	28656.9	34,010.90	30,921.00	44.1	2,884.60	-2,402.50	-2,264.10
БСУШУСайд	28640.9	33,113.30	31,810.10	45.3	1,534.90	-3,534.40	-3,169.20
БХБСайд	240.2	230.5	230.4	0.3	0.1	13.9	9.8
ХНХСайд	278.9	277.6	269.1	0.4	8.5	10.6	9.8
ЭМСайд	7331.5	7,075.10	6,957.50	9.9	91.2	522.9	374
ДҮН	65148.4	74,707.40	70,188.10	100	4,519.30	-5,389.50	-5,039.70

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар

Нэмэлт санхүүжилтийн дансны оны эхний үлдэгдэл 77.5 сая төгрөг, тайлант онд 1914.8 сая төгрөгийн орлого орж, 1981.8 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг авч үзвэл нийт зардлын 55.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 17.0 хувийг, цалин НДШ-д 6.0 хувийг зарцуулсан нь нийт зардлын 78.3 хувийг эзлэж байна.

зардлын нэр	мөнгөн дүн	Зардал эзлэх хувь
Цалин хөлс,нийгмийн даатгалын шимтгэл	120.4	6.3
Тогтмол зардал	58.4	3.0
Бараа материал хангамжийн	54.9	2.9
Эд хогшил,урсгал засварын зардал	60.8	3.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	326.7	17.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1059.4	55.3
Хөрөнгийн зардал	46.1	2.4
ОНТ-ийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас	134.5	7.0
Барилга байгууламж	19.8	1.0
Бие ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	26.3	1.4
Нормативт судалгаа	7.5	0.4
дүн	1914.8	100.0

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, эх үүсвэр бүрдүүлэлтэнд дараах зөрчлүүд илэрсэн байна.Үүнд:

- Аргалант сум нь 4.8 сая төгрөгийн татварын орлогыг, Алтанбулаг сум 6.7 сая төгрөгийн газрын суурь үнийг, Цээл сум нь 16.6 сая төгрөгийн газрын дуудлага худалдааны орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтын дансанд төвлөрүүлэн зарцуулсан
- Баян сум нь төрийн албан хаагчийн орон сууцны түрээсийн орлогын 1.1 сая төгрөгийг орон нутгийн татварын орлогын дансанд оруулалгүй сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтын дансанд оруулсан.
- Өндөрширээт сум нь Класнуэстайн майнинг ХХК-наас 0.3 сая төгрөгийн БОНСэргээлтийн барьцааг байршуулсныг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд оруулж зориулалт бусаар зарцуулсан

Дээрх алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 47.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж, төсвийн жилийн явцад Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, төсвийн урамшуулалаас бүрдсэн эх үүсвэрийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно гэсэн заалтыг зөрчин татварын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар оруулан зарцуулсан байна.

Гадаад томилолтын зардлын талаар

Төв аймаг нь 2016 оны төсөвт гадаад арга хэмжээний зардал батлагдаагүй. 2016 онд Аймгийн Засаг даргын нөөц сан болон ангилагдаагүй зардлаас нийт 85.4 сая төгрөгийг гадаад арга хэмжээнд оролцох онгоцны тийзний үнэ, томилолтын зардал, бэлэг дурсгал, орчуулга, гадаадын зочин төлөөлөгч хүлээн авч байрлуулах зэрэг зардалд зарцуулсан байна.

Энэ нь аймгийн гадаад харилцааны өнөөгийн хүрсэн түвшинг бататгаж, гадаад харилцааны бодлогын хүрээнд дараах 5 зорилт 22 арга хэмжээний ажил төлөвлөсөн байна. Үүнд:

- ✚ Төрийн албан хаагчид, хүүхэд багачуудаа харилцаат мужуудад урт богино хугацааны сургалт, семинарт хамруулах, сургах, дадлагажуулах, туршлага судлах, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах
- ✚ Олон улсын урлаг соёлын фестиваль, спортын арга хэмжээдэд оролцох, хамтран зохион байгуулах
- ✚ Олон улсын хэмжээний үзэсгэлэн, яармаг худалдаа, Экспод аймгийн үйлвэрлэл, бизнесийн төлөөллийг аймаг, орон нутгаа сурталчлах бүтээгдэхүүний хамт оролцуулах
- ✚ Гадаадын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж, дэмжин ажиллах
- ✚ Шинэ тутам харилцаа хамтын ажиллагааг улам өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд анхаарч ажиллах гэсэн зорилт дэвшүүлсэн байна.

2016 онд аймагт орж ирсэн бодит хөрөнгө оруулалт 571.2 сая төгрөг байна. Үүнд:

- ✓ Монголын Энхтайван, найрамдлын байгууллага, БНХАУ-ын Ардын энх тайван, Зэвсэг хураахын төлөө нийгэмлэгтэй байгуулсан Хандивын гэрээний дагуу Монгол улсын Төв аймагт цахилгаан эрчим хүчээр хангагдаагүй бүс нутаг /малчин айл өрх/, сургууль, цэцэрлэгт буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор 1064 ширхэг буюу 21.2 сая төгрөгийн нараар цэнэглэгч гэрэл хандивласан,
- ✓ БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт олгосон хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНД” төслийн хүрээнд 550.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт өгсөн байна.

3.2 Монгол Улсын өрийн удирдлага зүй зохистой, үр дүнтэй байгаа юу?

Төв аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Азийн хөгжлийн банкнаас дамжуулан зээлдүүлсэн 1847-MOH(SF) төслийн зээлийн авлага оны эхний үлдэгдэл 330.1 сая төгрөгөөс 80.8 сая төгрөгийг төлж, оны эцэст 249.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн MOH-2301 төслийн зээл оны эхний 2105.4 сая төгрөгийн авлага болон өглөг тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй

байна.ТСГ-ын өрийн удирдлагын хэлтэстэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан байна.

3.3 Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Төв аймагт улсын төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалт нь “Монгол улсын 2016 оны төсвийн тухай” хуулиар салбар яамдад батлагдсан зардлаас хуваарилагдсан байна. 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтад 604.9 сая төгрөг батлагдсан нь нийт 3 эх үүсвэр буюу 3 сайдын багцаас санхүүжүүлэхээр батлагджээ. Үүнд:

- ✚ Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж бэлтгэх ажлаас
 - ✓ Аймгийн Засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж худалдан авахад 100.0 сая төгрөг,
- ✚ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын шинээр хэрэгжих боловсролын салбарын барилга, байгууламжийн өргөтгөл, их засварын зардлаас
 - ✓ Зургаан Сургууль, цэцэрлэгийн барилгын их засварт 348.9 сая төгрөг,
- ✚ Эрүүл мэндийн салбарын шинээр хийгдэх их засварын зардлаас
 - ✓ ЭМТ-ийн хоёр барилгад 156.0 сая төгрөг батлагджээ.

Улсын төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг төрлөөр нь авч үзвэл:

- ✚ Бараа, материал худалдан авах 1 ажилд 100.0 сая төгрөг
- ✚ Барилгын 8 их засварын ажилд 504.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр батласан байна.

“Монгол улсын 2016 оны төсвийн тухай” хуулиар салбар яамнаас улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаас аймгийн ЗДТГ болон 8 суманд хуваарилагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 9 ажлаас 3 ажлын гэрээний хугацаа 2-4 сараар хэтэрсэн байна. Үүнд:

- ✚ Өндөрширээт сумын сургуулийн дээврийн засвар 100 хоног
- ✚ Лүн сумын сургуулийн дотуур байрны засвар 64 хоног
- ✚ Баянцогт сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засвар 110 хоногоор хугацаа хэтэрчээ.

Захиалагчаас гэрээний хугацаа хэтрүүлсэн нэг гүйцэтгэгч буюу Лүн сумын сургуулийн дотуур байрны засварын ажлыг гүйцэтгэсэн “Ар булаг” ХХК-нд 0.03 хувиар хугацаа хэтрүүлсний алданги 0.2 сая төгрөгийг тооцжээ.

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 592.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдан, зөвхөн гүйцэтгэгчийг санхүүжүүлэх 564.3 сая төгрөгнөөс 571.6 сая төгрөг буюу 7.3 сая төгрөгийг илүү олгожээ. Жишээлбэл:

- ✓ Баянцогт сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажилд “Титан оргил” ХХК-тай 49.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдан, техник хяналтын зардал, магадлашгүй ажлын зардал, зураг, төсвийн үнэнд нийт 2.0 сая төгрөг суутган тооцож, гүйцэтгэгчид 47.8 сая төгрөг олгохоос 49.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1.8 сая төгрөгийг илүү олгосон,
- ✓ Мөнгөнморьт сумын сургуулийн барилгын дээврийн засвар болон нэмэлт ажлын нийт 65.0 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, гүйцэтгэгчид 61.5 сая төгрөг олгохоос 64.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2.5 сая төгрөг илүү олгосон,
- ✓ Борнуурын цэцэрлэгийн барилгын дээврийн засварт нийт 49.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, гүйцэтгэгчид 47.2 сая төгрөг олгохоос 49.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1.8 сая төгрөг илүү олгосон байна.

Улсын төсвөөс 592.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй ажлыг дүгнэж, ажил хүлээлцэх комиссын актаар хүлээн авсан байна. 9 ажлаас 437.7 сая төгрөгийн 7 хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгасан байна.

3.4 ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрсэн үр дүн зорилтот түвшинг хангасан уу?

Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

д/д	ТЕЗ –ийн нэр, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр	2016 оны зорилтод түвшин	Үр дүнгийн хэрэгжилт	Зарцуулсан төсөв / сая төгрөг/
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга			
1.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	152 асуудал хэлэлцэж 96 тогтоол 33 тэмдэглэл ТХТ-71.7% ТТ-78.5% 12 хөндлөнгийн хяналт	117.1
1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хөтөлбөрийн хэрэгжилт 80%	Аймгийн төвд 2 удаагийн нэгдсэн сургалт, 1, 2 улиралд Аймгийн төв, 27 сумын хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан.Үүнд 960 иргэн оролцож давхардсан тоогоор 282 санал хэлсэн.	39.9
2	Аймгийн Засаг дарга			
2.1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Гүйцэтгэх засаглалын удирдлага тэдгээрийн ажлын алба Засаг захиргааны түвшин хоорондын шилжүүлэг, Засаг захиргааны түвшин хоорондын шилжүүлэг, Орон нутагт аймгаас санхүүгийн дэмжлэг олгох, Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг зориулалтын дагуу заруулсан	23163.6
3	Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх зохион байгуулах	18644	46940	7655.0
4	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ			
4.1	Сургуулийн өмнөх боловсрол / Хүүхдийн тоо/	7353	7383	8722
4.2	Ерөнхий боловсрол / Хүүхдийн тоо/	15398	15398	20467.6
4.3	Соёл, урлагын үйлчилгээ	59898	58600	2150.1
5.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	153410	276714	6872.5
5.2	Өрхийн эмнэлгийн үйлчилгээ	20450	78951	210.8
5.3	Нийтийн биен тамир спортын үйлчилгээ	14000	52851	781.9
	Нийт дүн			70180.5

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Төв аймгийн хувьд 2016 оны төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэлийг баримталж ажилласан байна
2. Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг тайлант хугацаанд 2 удаа тодотгон баталсан байна
3. Төв аймгийн 2016 оны төсвийн эх үүсвэр бүрэн санхүүжигдэж, татварын орлого давж биелэснээс 822.9 сая төгрөгөөр эх үүсвэр нэмэгдсэн байна.
4. Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлого 7 нэр төрөл дээр 8.8-39.0 хувиар тасарсан байна
5. Төв аймгийн 2016 оны төсвийн урсгал зардал 4526.9 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсан байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Ж.Батжаргал, Санхүү Төрийн Сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт нарт зөвлөх нь:

1. Орон нутгийн орлого эх үүсвэрийг бодитой төлөвлөж, татварын орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх
2. Азийн хөгжлийн банкнаас дамжуулан зээлдүүлсэн 1847-МОН(SF) төслийн зээл, гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн МОН-2301 төслийн зээлийн өр авлагын тооцоог графикийн дагуу тогтмол хийж хэвших

ТАЙЛАНГ ХЯНАСАН.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Ц.САРАНЧИМЭГ

АУДИТОР:

Ц.БАЗАРСАД

А.БАТЛХАГВА

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273623, Факс: 70272237

2014.04.22 № 05/698
танай -ны № -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Төв аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хүлээн
зөвшөөрч, хэрэгжүүлэн ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ю.БЯМБАЦОГТ



02 0587
My.doc: TootA5-2/2017